

БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Тэшиг сумын ойн анги 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БУА-2022/164/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Булган аймаг 2022 он	Дарга, тэргүүлэх аудитор: Д.Анхбаяр Утас: 70342580 Цахим хаяг: Ankhubayard@audit.gov.mn Аудитын менежер: Ж.Энхцоодол Утас: 70342716 Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn Аудитор: З.Ганбаатар Утас: 70342495 Цахим хаяг: ganbaatarz@audit.gov.mn
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	Error! Bookmark not defined.
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
3. Аудитын тайлан.....	6
3.1 Ерөнхий зүйл.....	6
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	Error! Bookmark not defined.
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	7
3.4 Материаллаг байдал	7
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	8
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	8
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	9
3.8 Аудитын гол асуудал	9
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	9
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	9
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	9
4. Аудитын илрүүлэлт	9
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	11

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**БУЛГАН АЙМГИЙН
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс: 7034-3259
E-mail: bulgan@audit.gov.mn

2022.02.25 № 74

танай _____ ны № _____ т

ТЭШИГ СУМЫН ОЙН
АНГИЙН ДАРГА Г.СҮХБАТ
ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Тэшиг сумын Ойн ангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Тэшиг сумын Ойн ангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх

D:\bichighereg\2022A4\toot

006020114

үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.АНХБАЯР

D:/bichighereg/2022A4toot

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	-	3,787,716.88
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	1,167,826.88
312	Банканд байгаа бэлэн мөнгө	-	1,167,826.88
3122	Гадаад валют	-	1,167,826.88
31223	Арилжааны банк дахь харилцах	-	1,167,826.88
33	АВЛАГА	-	2,619,890.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	-	2,619,890.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	-	3,787,716.88
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	-	3,787,716.88
51	Засгийн газрын хувь оролцоо	-	3,787,716.88
512	Хуримтлагдсан үр дүн	-	3,787,716.88
51220	Тайлант үеийн үр дүн	-	3,787,716.88
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	-	3,787,716.88

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	-	19,947,500.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	19,947,500.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	19,947,500.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	19,947,500.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	19,947,500.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	-	16,159,783.12
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	16,159,783.12
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	16,159,783.12
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	13,873,247.38
210101	Үндсэн цалин	-	13,873,247.38
2104	Хангамж, бараа материалын зардал	-	450,800.00
210401	Бичиг хэрэг	-	158,000.00
210402	Тээвэр, шатахуун	-	292,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	1,835,735.74
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	1,835,735.74
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-	3,787,716.88
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-	3,787,716.88

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл				
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл				

**Тэшиг сумын ойн ангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

D08	Тайлант үеийн үр дүн			3,787,716.88	3,787,716.88
D09	2020 оны 12-р сарын 31- нээрх үлдэгдэл			3,787,716.88	3,787,716.88

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	-	17,327,610.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	17,327,610.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	17,327,610.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	17,327,610.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	17,327,610.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	-	16,159,783.12
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	16,159,783.12
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	16,159,783.12
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	13,873,247.38
210101	Үндсэн цалин	-	13,873,247.38
2104	Хангамж, бараа материалын зардал	-	450,800.00
210401	Бичиг хэрэг	-	158,000.00
210402	Тээвэр, шатахуун	-	292,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	1,835,735.74
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	1,835,735.74
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	-	1,167,826.88
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	1,167,826.88
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	1,167,826.88

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	0.00	16159783.12
21	УРСГАЛ ЗАРДАЛ	0.00	16159783.12
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0.00	16159783.12
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	0.00	13873247.38
210101	Үндсэн цалин	0.00	13873247.38
2104	Хангамж, бараа материалын зардал	0.00	450800.00
210401	Бичиг хэрэг	0.00	158000.00
210402	Тээвэр, шатахуун	0.00	292800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	1,835,735.74
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	1,835,735.74
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		1,167,826.88

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны

дагуу Тэшиг сумын ойн ангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд санхүүгийн тайлан, бүртгэлд гарсан алдаа зөрчилтэй, холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг аудитор З.Ганбаатар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, дарга, тэргүүлэх аудитор Д.Анхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Тэшиг сумын ойн ангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Тэшиг сумын ойн анги нь Ойн ангийн үйл ажиллагааны үндсэн чиг үүргийг тогтоох, удирдлага, зохион байгуулалтын бүтэц, хяналт, үйлдвэрлэлийн газрын эд хөрөнгийн эрх, түүнийг өөрчлөн байгуулах, бүртгүүлэх зэрэгтэй холбогдох үйл ажиллагааны харилцааг хууль тогтоомжид нийцүүлэн зохицуулахад оршино.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Тус байгууллага нь 2021 онд дотоод хяналт шалгалтын төлөвлөгөөг боловсруулан ажиллаагүй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тэшиг сумын ойн анги нь бүтэц орон тоонд дотоод аудит байхгүй бөгөөд дээд шатны төсөв захирагчийн санхүүгийн хяналт, дотоод аудитын хэлтэс 2021 онд төлөвлөгөөт хяналт шалгалт хийгдээгүй байна.

3.3 САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Тэшиг сумын ойн анги нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны нийт орлогыг 17,327.6 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 173.3 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 121.3 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Тэшиг сумын ойн ангийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 3,787.7 буюу 100 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

			/Мян.төг /
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	1,167.8	1,167.8
Авлага	0	2,619.8	2,619.8
Урьдчилгаа			
Бараа материал			
Үндсэн хөрөнгө			
Нийт хөрөнгө	0	3,787.7	3,787.7
Өр төлбөр			
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	0	3,787.7	3,787.7
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн		3,787.7	3,787.7

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 1,167.8 мянган төгрөг болж 1,167.8 мянган төгрөгөөр өссөн нь үйл ажиллагаа явуулж эхэлснээс шалтгаалжээ. Энэ нь Тэшиг Ойн Анги нь урд жилүүдэд үйл ажиллагаа эрхлээгүй зогсонги байснаас 2021 оны 2 дугаар сараас эхлэн үйл ажиллагаагаа эхэлсэн байна.

Авлага: Авлага дансны үлдэгдэл 2,619.8 мянган төгрөг болж 2,619.8 мянган төгрөгөөр өссөн нь талбай тусгаарлалтын орлого дутуу төвлөрүүлснээс шалтгаалсан байна.

Бараа материал: Тайлант онд бараа материалын дансанд 450.8 мянган төгрөгийн бараа материалыг орлогодож үлдэгдэлгүй зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө: Тус байгууллага нь одоогоор бүртгэлтэй үндсэн хөрөнгө байхгүй

Өр төлбөр: Тайлант онд өр төлбөрийн үлдэгдэлгүй байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллага нь 2021 оны 02 дугаар сараас эхлэн үйл ажиллагааг явуулсан төсвийн төлөвлөлт байхгүй байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр үндсэн үйл ажиллагаанаас 17,327.6 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 16,159.8 мянган төгрөгийг зарцуулж 1,167.8 мянган төгрөгийн дансны үлдэгдэлтэй байна.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт төсвийн орлого байхгүй байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

3.8 Аудитын гол асуудал

Тайлан үеийн санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх асуудлууд үүсээгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх "Байгууллага нь шилэн дансны мэдээллийг өөрийн цахим хуудсаар хүргэх бөгөөд цахим хуудас нь дараах шаардлагыг хангасан байна" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Санхүүгийн тайлангийн бодит байдлын тухай мэдэгдлийг бүрдүүлж хавсаргаагүй, төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь заалтыг бүрэн хэрэгжүүлэн ажиллаагүй, санхүүгийн тайлангийн аудитын үнэн зөв батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт Өмнөх онд үйл ажиллагаа явуулаагүй байсан.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тайлант онд төсвийг батлаагүй үйл ажиллагаа явуулсан.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 2,619.8 мянган төгрөгийн 6 алдаа зөрчил илэрснээс, 2,619.8 мянган төгрөгийн 1 алдааг залруулж, 1 албан шаардлага, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өгсөн байна.

4.1 Залруулсан алдаа

Худалдан авсан 1,250.0 мянган төгрөгийн хөрөнгийг шууд зардалд бичсэн нь НББ-ийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтлөлтөд гарсан алдааг алдаа гарсан шалтгаан, залруулах аргыг тодорхой тусгасан баримт, тайланг үндэслэн залруулах бөгөөд зөвшөөрсөн болон залруулга хийсэн албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулна." 15.2 дахь "Нягтлан бодох

бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна." гэсэн заалтын дагуу залруулга хийсэн.

4.2 Төлбөрийн акт

4.3 Албан шаардлага

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Тайлангийн иж бүрдэлтэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Жилийн эцсийн санхүүгийн тайлангийн иж бүрдлийг төсвийн тухай хуульд зааснаар бэлтгээгүй байна.

Энэ нь төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь заалтыг бүрэн хэрэгжүүлээгүй, санхүүгийн тайлангийн аудитын үнэн зөв батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь заалтыг бүрэн хэрэгжүүлж ажиллах.

2. Авлагын данстай холбоотой асуудал

3.1 Илрүүлэлт:

Тайлан онд 2.619,890.0 төгрөгийн авлага үүсгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй бай" гэсэн заалттай бүрэн нийцэхгүй байна.

3.2 Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх." гэсэн заалтыг мөрдөж ажиллах.

3. Дотоод ажилтай холбоотой асуудал

3.1 Илрүүлэлт:

Булган аймгийн Тэшиг сумын ИТХ-ын 2016 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 14/03 дугаар тогтоолд заасан заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Тэшиг сумын ИТХ-ын 2016 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 14/03 дугаар тогтоолын 3 дугаар зүйлийн 3.1, 3.2, дахь заалтыг хэрэгжүүлж ажиллах.

3.2 Өгсөн зөвлөмж: Тэшиг сумын ИТХ-ын 2016 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 14/03 дугаар тогтоолын 3 дугаар зүйлийн 3.1, 3.2, дахь заалтыг хэрэгжүүлж ажиллах.

4. Дотоод хяналттай холбоотой асуудал

3.1 Илрүүлэлт:

Дотоод хяналт шалгалтын журам батлаагүй хяналт шалгалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Тэшиг сумын ИТХ-ын 2016 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 14/03 дугаар тогтоолын 7 дугаар зүйлийн 7.1-д заасны дагуу дотоод хяналтын журмыг баталж ажиллах.

3.2 Өгсөн зөвлөмж:

Дотоод хяналт шалгалтын журмыг ЗГ-ын 2011 оны 311 дүгээр тогтоол болон сумын ИТХ-ын 7 дугаар зүйлийн 7.1-д заасны дагуу боловсруулж мөрдлөг болгох.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 07 дугаар сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/Мян.Төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Тэшиг сумын ойн анги	6	2,619.8	1	2,619.8			1	0	4	0
Нийт дүн		6	2,619.8	1	2,619.8			1	0	4	0